



БАЯНХОНГОР АЙМАГ
БААЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 30 өдөр

Дугаар А/67

Баянсайр

“Хүүхдийг эрхийг хамгаалах өдөр”-ийг
тэмдэглэн өнгөрүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2 дугаар зүйлийн 2.1.3, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 17.1.1, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Олон Улсын “Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг сумын хэмжээнд “Хүүхэд бүхэн аз жаргалтай байг” уриан дор удирдамжийн дагуу тэмдэглэн өнгөрүүлсүгэй.

2. “Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийн арга хэмжээг зохион байгуулж, удирдлага арга зүйгээр ханган ажиллах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, баярын үйл ажиллагаанд зарцуулагдах зардлын тооцоог хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. “Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийн арга хэмжээд зарцуулагдах 1293600,0 (Нэг сая хоёр зуун ерэн зургаан мянга зургаан зуун) төгрөгийг Засаг даргын нөөцөөс гарган зарцуулахыг Тамгын газрын дарга (Б.Наранбаатар), нягтлан бодогч (Д.Анхтуяа)-нарт зөвшөөрсүгэй.


3. Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийн арга хэмжээг удирдамжийн дагуу зохион байгуулж, тайлан мэдээ, холбогдох баримт бичгийг гарган бүрдүүлэхийг ажлын хэсгийн нарийн бичгийн дарга (Б.Отгонжаргал)-д үүрэг болгосугай.

ДАРГА С.ЭНХТӨР



642101409

Сумын Засаг даргын оны
дугаар сарын ны өдрийн дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт



**“ХҮҮХЭД БҮХЭН АЗ ЖРГАЛТАЙ БАЙГ” УРИАН ДОР
ТЭМДЭГЛЭХ“ ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ӨДӨР”-ИЙГ
УДИРДЛАГА АРГА ЗҮЙГЭЭР ХАНГАН АЖИЛЛАХ
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн ахлагч: Б.Бямбаням(Засаг даргын орлогч)

Гишүүд: Б.Наранбаатар (Тамгын газрын дарг)

Г.Насанбаяр (Сургуулийн захирал)

Д.Болормаа (Эрүүл мэндийн төвийн дарга)

Х.Соёл -Эрдэнэ (Соёлын төвийн эрхлэгч)

Ч.Энхтуяа (Цэцэрлэгийн эрхлэгч)

Нарийн бичгийн дарга:

Б.Отгонжаргал (Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

_____оОо_____